

ХОРИХ БАЙГУУЛЛАГА ДАХЬ НИЙГЭМШҮҮЛЭХ АЖИЛД ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ОРОЛЦОО, ХАМТЫН АЖИЛЛАГАА

PARTICIPATION AND COOPERATION LAW ENFORCEMENT AGENCIES OF SOCIALIZATION WORK AT THE PRISON



Г.ГАЛСАНЖАМЦ

ХСИС-ийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, ахлах дэслэгч

GALSANJAMTS G.

Senior Research Officer of Execution of Court Decision Department of Researching and Developing institute, Law Enforcement University, Second Lieutenant

ГАЛСАНЖАМЦ Ж.

Старший научный сотрудник центра исследования исполнения судебных решений Института науки и развития Университета правоохранительной службы, старший лейтенант

Товч утга: Энэхүү өгүүлэлд ялтныг нийгэмшүүлэх ажилд хууль сахиулах байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагаа, үйл ажиллагааны хамрах хүрээг авч үзсэн бөгөөд гадаадын зарим оронд хэрэгжүүлж буй ялтныг нийгэмшүүлэх ажлын туршлага, төсөл, хөтөлбөрийн онцлогыг тусгаж, хамтын ажиллагааны саналыг дэвшүүлсэн болно.

Abstract: This article about participation and cooperation law enforcement agencies of socialization work at the prison, considering the scope of work of the foreign prisoner socialization experience implemented in some countries, projects and programs that reflect the nature of proposed co-operation.

Түлхүүр үгс: Хорих байгууллага, нийгэмшүүлэх ажил, ялан, хууль сахиулах байгууллага, давтан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагаа, оролцоо.

Key words: Prison organization, socialization work, a convict, law enforcement agencies, Re-crime prevention, cooperation, participation.

Аливаа улс орны хөгжлийн бодлогын үндсэн чиглэл нь нийгмийн гол үнэт зүйл болсон хүний хөгжлийг дэмжсэн нөхцөлд эерэг үр дүн гардаг гэдгийг угсаатны зүй, сэтгэл судлал, социологийн шинжлэх ухаан болон хүний хөгжлийн зүй тогтлыг судалдаг эрдэмтэн судлаачид нэгэнт тогтоосон байдаг.

Хүний хөгжил рүү чиглэсэн үйл ажиллагааны нэг хэсэг нь нийгмийнхээ эмзэг бүлэгт тусалж, тэдгээрийг нийгэмд тодорхой байр суурьтай, үүрэг хариуцлагатай болгон хөгжүүлэх буюу зарим тодорхой бүлгийн хүмүүсийг нийгэмшүүлэх асуудал бөгөөд энэ ажлын зөв, оновчтой арга хэлбэрийг тогтоох, салбар хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх, ажлын уялдаа холбоог сайжруулах ажил чухлаар тавигдаж байна.

Гэмт хэрэг үйлдсэний улмаас шүүхээр шийтгэгдэн ял эдэлж буй ялан болон хорих байгууллагаас суллагдсан иргэд нь шаардлагатай тохиолдолд нийгмийн халамжийн дэмжлэг, тусламж авах, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах зорилтод бүлэгт хамаарах иргэд учраас тэдэнд үзүүлэх нийгэм, сэтгэл зүйн ажлыг дан ганц хорих байгууллагын чиг үүргээр хязгаарлахгүйгээр хууль сахиулах байгууллагын оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлан хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн болно.

Дэлхийн улс орнуудаас хорил ял эдэлж буй ялтны тоогоор АНУ, БНХАУ, ОХУ эхний гуравт, Монгол Улс 104-д, Азийн орнуудаас 26-д ордог төдийгүй 100 мянган хүн амд ногдох ялтны тоогоор Азид 42-д ордог¹ бөгөөд ба сүүлийн 5 жилийн байдлаар хорих ял эдлэгсдийн тоо өссөн үзүүлэлттэй² (2008 онд 6289, 2011 онд 6911, 2013 онд 6868, 2015 онд 6484), давтан гэмт хэрэг үйлдэгсдийн тоо буурахгүй (38.4 хувь нь давтан гэмт хэрэг үйлдсэн) байна.³

Хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн хүрээнд хорих ял эдлэгсдийг суллах, нийгэмшүүлэхэд чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг⁴ судалж үзэхэд, төрийн эсрэг, хүний нэр төр, алдар хүндийн эсрэг, хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг үйлдэж 5-аас дээш жил хорих ял эдэлсэн, дээрх гэмт хэргийг давтан үйлдсэн хүмүүст захиргааны хяналт тогтоохоор заажээ. Өөрөөр хэлбэл, хорих ял эдлэгсдийг нийгэмшүүлэх, суллагдсаны дараа нийгэмд бие даан оролцох боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр буюу нийгмийн зүгээс дэмжлэг үзүүлэх, нөхөн сэргээх үйл ажиллагааны хэлбэр огт тусгагдаагүй, хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааны бодлого, эрх зүйн зохицуулалт бүрдээгүй байгааг илэрхийлж байна.

Хууль сахиулах салбарын ажилтны болон хорих ял эдлүүлэх ажиллагаанд холбогдох НҮБ-аас гаргасан барим бичгүүд болох Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд⁵, Хоригдлуудтай харьцах үндсэн зарчмууд⁶, Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц⁷, Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль⁸, Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмууд⁹ зэрэг олон улсын баримт бичигт хорих ял эдлүүлэх үйл ажиллагаанд хүний суурь эрх, эрх чөлөөг хангах, хүндэтгэн үзэх зарчмыг тусгаснаас гадна ялтныг сурч боловсрох, хөгжүүлэх талаар бүх талын дэмжлэг, тусалцаа үзүүлэх, тэднийг олон нийтийн болон нийгмийн байгууллагуудын оролцоо, тусламжтайгаар нийгэмшүүлэх, нийгмийн амьдралд эргэн орох таатай нөхцлийг

¹ <http://www.idcr.org.uk/wp-content/uploads/.pdf>

² ШШГЕГ-ын ТТГ-ын Тоо бүртгэлийн тасгийн 2015 оны 1 дүгээр улирлын мэдээ

³ ШШГЕГ-ын ТТГ-ын Тоо бүртгэлийн тасгийн 2015 оны 1 дүгээр улирлын мэдээ

⁴ - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15 дугаар зүйлд “Хорих ял эдлээд суллагдсан хүнд захиргааны хяналт тогтоох” тухай,

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.5-т “Ялтан суллагдвал энэ тухай Тахарын албанд мэдэгдэнэ” гэж,

- Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйлийн 61.4-д “тэнсэгдсэн ялтанд цагдаагийн байгууллага хяналт тавина” гэж,

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 104 дүгээр зүйлийн 104.1-д “Хорих ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллагдсан болон Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйлд заасан үндэслэлээр тэнсэгдсэн ялтанд цагдаагийн байгууллага хяналт тавина” гэж,

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 104 дүгээр зүйлийн 104.1-т “Албадан ажил хийлгэх, баривчлах, хорих ял нь шүүхийн шийтгэх тогтоолоор хойшлогдсон ялтанд цагдаагийн байгууллага хяналт тавина.” гэж тус тус заасан байна.

⁵ 1955 онд Женевт хуралдсан НҮБ-ын нэгдүгээр их хурлаар баталсан.

⁶ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1990 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 45/111 дүгээр тогтоолоор баталсан.

⁷ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1988 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 43/173 дугаар тогтоолоор баталсан.

⁸ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1979 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 34/169 дүгээр тогтоолоор баталсан.

⁹ 1990 онд Кубын Гавана хотноо хуралдсан НҮБ-ын Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх эрх зүйн зөрчил үйлдэгдсэд хандах асуудлаарх наймдугаар их хурлаар баталсан.

бүрдүүлсэн байхаар тодорхойлсон байна.

Гадаадын зарим орны хорих байгууллага дахь ялтныг нийгэмшүүлэх ажлын бүхий л арга, хэлбэр нь тэдэнд зан үйлийн болон сэтгэл зүйн нөхөн сэргээлт явуулах, суллагдсаны дараа нийгэмд дасан зохицох, нийгмийн амьдралд бие даан оролцох, гэмт хэрэг, зөрчилд холбогдохгүй байхад чиглэгдэж, энэ ажилд ялтны гэр бүлийн гишүүд, найз нөхөд, асрамжийн болон нийгмийн халамжийн, шашны, боловсролын, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих байгууллагууд, түүнчлэн хууль сахиулах зэрэг төрийн болон төрийн бус, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг чухалчлан үздэг байна. Тухайлбал, хууль сахиулахын байгууллагуудын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн ялтныг нийгэмшүүлэх, тэднийг олон нийтэд зөв ойлгуулах буюу нийгмийн сэтгэл зүйг бэлтгэх зэргээр хамтарсан дараах төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлж буй туршлагууд байна:

- “Өөрөө өөрийгөө хянах” хөтөлбөр

Өндөр хөгжилтэй орнуудын хорих ял эдлүүлэх ажиллагаанд нэвтрүүлж буй хяналтын үр дүнтэй нэг арга нь ухаалаг технологи буюу техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг өргөнөөр нэвтрүүлсэн явдал юм. Өөрөөр хэлбэл, ял эдэлж буй ялтан ухаалаг технологийн тусламжтайгаар “өөрөө өөрийгөө хянах” тогтолцоонд шилжиж, энэ нь хувь хүний хариуцлагыг нэмэгдүүлэх агуулгатайгаар хэрэгжиж байна.

Тухайлбал, ухаалаг утасны технологийг ашиглан тухайн хүний зан үйлийг судлахаас эхлээд хийж гүйцэтгэж буй бүхий л үйлдлийг бүртгэн судалж, ялтанд өөрт нь ял эдлэх хугацаандаа хийвэл зохих зүйлсийн хэдэн хувийг гүйцэтгэсэн, ямар нэгэн зөрчил гаргасан эсэх, гэм хорын төлбөрийн хэдэн хувийг төлсөн зэргийг автоматаар мэдээлж, тухай ялтан суллагдахын тулд тодорхой шалгуурыг хангасан байх ёстойг ойлгуулж, түүнийг удирдан чиглүүлэх боломжтой төдийгүй сургалт, нөлөөллийн ажлыг ч гүйцэтгэх, улмаар бие даан мэргэжил, боловсрол эзэмшүүлэх боломжийг давхар олгож болно.

Мөн цахим гавыг ашиглан явах чиглэл, маршрутыг хязгаарлан зарим ялтныг аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр ажиллуулах, хурууны хээгээр ажлын цагийг бүртгэх, ямар төрлийн ажлыг хэдий хугацаанд хийж гүйцэтгэн, хэдэн төгрөгийн цалин авах зэргийг ухаалаг технологийг ашиглан мэдээлж, хяналт тавих шинэ арга хэрэглэж байна.

Эдгээр үйл ажиллагаануудад хорих байгууллага, оршин суух болон тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлж буй нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага, боловсролын байгууллагууд зэрэг салбарын бүрэлдэхүүн оролцож, нэгдсэн системээр тухайн ялтныг нийгэмшүүлэхэд бэлтгэж, тодорхой хугацааны дараа үнэлж, дүгнэх, урамшуулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг тогтолцоо байна.

Энэ нь тухайн ялтны гүйцэтгэж буй үйл ажиллагаа болон байгууллага хооронд хамтын ажиллагаа – хяналтын системийн зарчмаар хэрэгжихээс гадна хувь хүнд өөрийн үнэлэмж, зорилго бий болгох, өөртэйгээ ажиллах боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой хөтөлбөрүүдийн нэг байна.

- Боловсролын болон мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөр

Бодлогын судалгааны олон улсын байгууллага болох RAND корпорацийн хийсэн судалгаанаас үзэхэд¹⁰ боловсролын болон мэргэжлийн чиг баримжаа

¹⁰ Federal Bureau of Justice Assistance. Robert Bozick, Jennifer Steele, Jessica Saunders and Jeremy Miles (August 22, 2013). Education and Vocational Training in Prisons Reduces Recidivism, Improves Job Outlook.

олгох хөтөлбөрт хамрагдсан ялтнууд нь тус хөтөлбөрт хамрагдаагүй ялтнуудтай харьцуулахад дахин гэмт хэрэг үйлдэх хувь маш бага байсан ба тэд боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлснээрээ суллагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэн, хорих ял эдлэхтэй холбоотой төсөв хөрөнгийг 4-5 дахин бууруулж байгааг судлан тогтоосон байна.

Манай улсын хувьд нийт ял эдлэгсдийн 32 хувь нь бүрэн бус дунд, 27.9 хувь нь бүрэн дунд, 4.6 хувь нь дээд боловсролтой байх ба 53.9 хувь нь тодорхой мэргэжилгүй, 90 орчим хувийг хөдөлмөр эрхлэх чадвартай буюу 45 хүртэлх насны ялтан эзэлж байна.¹¹

Боловсролын үйлчилгээг ял эдлэгсдэд хүртээмжтэй хүргэснээр суллагдсаны дараа ажил хөдөлмөр эрхэлж, бие даан амьдрах, нийгэмших нөхцөл боломж илүүтэй бүрдэх учраас тэдний мэдлэг, боловсролыг дээшлүүлэх ажлыг хорих байгууллагын онцлог, ял эдлэгсдийн боловсролын хэрэгцээнд нийцүүлж, суллагдсаны дараа шууд үргэлжлүүлэн суралцах боломжийг бүрдүүлж, тодорхой системтэйгээр буюу бичиг үсгийн боловсрол олгох, суурь боловсрол олгох, мэргэжлийн боловсрол олгох, амьдрах ухааны боловсрол олгох хэлбэрээр хэрэгжүүлэх боломжтой байна. Ялангуяа амьдрах ухааны боловсрол олгох ажилд хууль сахиулах байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, хамтран ажиллах боломжтой юм.

- Суллагдсаны дараах хөтөлбөр

Хорих ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг хувь хүндээ чиглэсэн буюу ялтныг нийгмийн хэм хэмжээнд нийцүүлэн бие даан амьдрах чадварыг эзэмшүүлэх чиглэлд анхаарч, ялтныг нийгэмшүүлэх үйл ажиллагааг зөвхөн хорих ангид байх хугацаанд хэрэгжүүлэхээр хязгаарлахгүй бөгөөд зарим улс орны туршлагаас харахад суллагдсаны дараах хөтөлбөрт 2 жил ба түүнээс дээш хугацаагаар хамруулах нь үр дүнтэй гэж үзжээ.¹²

Хорих байгууллагаас суллагдсан иргэнийг нийгэмшүүлэх, бие даасан эрх зүйн зохицуулалт, төрийн салбар институци-Пробацийн албыг бий болгон хөгжүүлэх¹³ асуудлыг судлаачид дэвшүүлэн тавьж байгаа бөгөөд энэхүү алба нь гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээдийг нийгмийн харилцаа, орчноос тусгаарлахгүй байх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг дахин гэмт хэрэг үйлдэх зан үйлээс татгалзуулах, урьдчилан сэргийлэх, тэднийг нийгмийн амьдралд эргэн ороход дэмжлэг, туслалцаа үзүүлэх, хууль сахин биелүүлэх, бусадтай зөв харилцаанд орох чадвар эзэмшүүлэх, хөгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх юм. Тухайлбал, ХБНГУ-д суллагдсан хүмүүсийн 40 хувь нь эхний 5 жилд ямар нэгэн хэмжээгээр хууль давтан зөрчдөггүй гэсэн тооцоо гарсан нь суллагдсаны дараах үйлчилгээний томоохон амжилт гэж үздэг байна.¹⁴

Ихэнхи улс орнуудад Пробацийн албанд нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, социологич зэрэг мэргэжилтнийг ажиллуулж, сайн дурын ажилтан, төрийн бус байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага, хууль сахиулах байгууллагуудын дэмжлэгийг авч ажилладаг туршлагыг нэвтрүүлэх боломжтой байна.

¹¹ ШШГЕГ-ын Нийгэм, сэтгэл зүйн тасгийн 2015 оны 1 дүгээр улирлын мэдээ.

¹² Maurice Chamman (February 16, 2013). A Prison Entrepreneur ship Program session. Inmates are taught skills including finance, market research and business etiquette.

¹³ Очгэрэл.Ц, Хорих байгууллагаас суллагдсдыг нийгэмшүүлэх шаардлага, тогтолцооны шинэчлэл илтгэл, ШШГС сэтгүүл, 2015, № 02, 03

¹⁴ Пүрэвсүрэн. О, "Герман улсын хорих байгууллага" гарын авлага, УБ., 2015.

- “Ажил ба гэр” хөтөлбөр

Энэхүү хөтөлбөр нь Сингапурын хорих байгууллагад хэрэгждэг бөгөөд ялтныг нийгэмшүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажлыг хорих ангийн болон чөлөөт нийгмийн гэсэн 2 түвшинд хэрэгжүүлж байна. Тухайлбал, хорих ангид цагдаа болон хууль сахиулах байгууллагын ажилтнуудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө мэдээлэл, мэдлэг олгох сургалтын ажлыг зохион байгуулж, ял эдлүүлэх ажиллагаа нь ажил хөдөлмөр эрхлэлт, гэр бүлд чиглэсэн нийгэмшүүлэх ажлын хэлбэртэй байна.

Ажил эрхлэлт, гэр бүлийн тогтвортой байдал нь ялтныг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх үндсэн арга гэж үзэн 2002 онд “Ялтныг нийгэмшүүлэх аргачлал”-ыг (*The Rehabilitation Framework*) гаргасан бөгөөд ялтныг тогтмол ажлын байраар хангах ажлыг Сингапурын нийгэмшүүлэх ажлын энтерпрайс (the Singapore Corporation of Rehabilitative Enterprises(SCORE))-тай хамтран, гэр бүлд нь дэмжлэг үзүүлэх ажлыг “Гэр бүлийн хөгжлийг дэмжих төв”-өөр дамжуулж, зөвлөгөө мэдээлэл өгөх, богино хугацааны санхүүгийн тусламж, зээл олгох зэрэг ажлуудыг хэрэгжүүлж байна.

Мөн ял эдэлсэн хүмүүсийг нийгэмшүүлэх хамтын ажиллагаа (Action for the Rehabilitation of Ex-Offenders) сүлжээг үүсгэн байгуулсан бөгөөд сүлжээний хийсэн томоохон алхам бол the Yellow Ribbon Project буюу Шар тууз хөтөлбөр¹⁵ бөгөөд ялтныг нийгмийн амьдралд ороход нь дэмжлэг үзүүлэх, олон нийтийн дэмжлэгийг хүлээхэд нь туслах зорилготойгоор төрийн болон төрийн бус олон байгууллагыг татан оролцуулжээ.

Ялтныг нийгэмшүүлэх ажлын чиглэлээр хэрэгжүүлж буй ихэнхи хөтөлбөр, арга хэмжээг үе шаттай байх, хамтын оролцоонд тулгуурласан байх, залгамж холбоотой байх, олон талт байх зарчмуудыг баримтлаж хэрэгжүүлэхээс гадна ялтны хувийн чадавх нийгэмд байр сууриа бүрэн дүүрэн олох боломжтой болох хүртэлх хугацаанд тасралтгүй хэрэгжүүлдэг жишиг байгаа нь харагдаж байна.

Гадаадын улс орнуудад хэрэгжүүлж буй ялтныг нийгэмшүүлэхэд чиглэгдсэн дээрх арга хэмжээг дүгнэн үзэхэд ял эдэлж байгаа хүмүүсийг нийгэмшүүлэх, нийгэмд дасан зохицоход нь туслалцаа дэмжлэг үзүүлэх ажлыг нийгмийн үйлчилгээний нэг төрөл¹⁶ гэж үзэж, тусгайлсан хуулиар зохицуулах¹⁷, зарим улсад ялтныг нийгэмшүүлэх ажлыг төрийн буюу хууль сахиулах аль нэг байгууллагаар гүйцэтгүүлдэг байна.¹⁸

¹⁵ <http://www.yellowribbon.org.sg/>

¹⁶ Шоронгоос суллагдсан хүмүүсийг нийгэмшихэд нь туслалцаа дэмжлэг үзүүлэх ойлголтыг нийтлэг байдлаар “resocialization эсвэл reintegration and rehabilitation of criminal offender” хэмээн томъёолж, зохицуулсан

¹⁷ - Япон улсад 1995 онд “Гэмт хэрэг, зөрчил гаргагчийг нийгэмшүүлэх тухай” хууль, 1996 онд “Сайн дурын пробацын албаны тухай” хуулийг тус тус баталсан.

- Англи улсад “The rehabilitation of offender act” гэсэн хууль үйлчилдэг бөгөөд түүнд заасан арга хэрэгслээр шоронд байгаа болон суллагдсан хүмүүст нийгмийн ажил, үйлчилгээ үзүүлэх хугацаа зэргийг зохицуулсан байдаг.

- ОХУ-ын Холбооны бүгд хурлаас 2010 оны 2 дугаар сарын 17-ны өдөр “Ял эдлэгсдийг нийгэмшүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох тухай” тогтоол гаргасан.

¹⁸ АНУ-д Halfway house, Сингапурт Нийгэмшүүлэх ажлын энтерпрайс (the Singapore Corporation of Rehabilitative Enterprises(SCORE)), Япон Улсын хууль зүйн яамын харьяанд Нийгэмшүүлэх, нийгмийн ажлын товчоо зэрэг байгууллагууд нь хорих ял эдлэгсдийг нийгэмшүүлэх, суллагдсаны дараа эргэн нийгэмшихэд нь дэмжлэг үзүүлдэг бөгөөд хагас хяналттай, хууль сахиулах байгууллагын туслалцааг авах хэлбэрээр хамтран ажилладаг, тусгайлсан институтууд байна.

Ялтныг нийгэмшүүлэх ажлын зохион байгуулалт, хэлбэр, хамтын ажиллагаа, эрх зүйн зохицуулалтыг нэгтгэн үзвэл, *social control* буюу нийгэм-захиргааны хяналт тогтоох гэсэн манай улсад байгаа загвар нь постсоциалист зарим оронд, *probation parole* буюу тусгайлсан алба, ажилтан хяналт тавьж, дэмжлэг үзүүлэн ажиллах гэсэн үндсэн хандлага байна.

Дээрх дүгнэлтэд үндэслэн цаашид гэмт хэрэг үйлдсэний улмаас хорих ял эдэлж буй ялтныг нийгэмшүүлэх, давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгэмд бие даан амьдрах чадвар эзэмшүүлэх, нийгэмшүүлэх ажилд хууль сахиулах байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр дараах саналыг дэвшүүлж байна.

Үүнд:

- Шүүн таслах, ял эдлүүлэх, нийгэмшүүлэх, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж буй хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн нэгдсэн санг бий болгож, мэдээлэл солилцоог гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ялтныг нийгэмшүүлэх хамтын ажиллагаанд ашиглах;

- Улсын хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэргийн болон гэмт хэрэг үйлдэгдэж буй шалтгаан, нөхцлийг судлан тогтоох чиглэлээр хууль сахиулах байгууллагуудаас хамтарсан судалгааны ажил явуулах, судалгаанд үндэслэж давтан үйлдэгдэх эрсдэлийн үнэлгээг хийж, урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлэх;

- Ялтныг нийгмийн хэм хэмжээнд нийцүүлэн бие даан амьдрах чадварыг эзэмшүүлэх, хууль сахин биелүүлэх, нийгэмшүүлэх хөтөлбөрүүдийг хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа, илтгэлд дурдагдсан гадаадын улсуудын жишигт тулгуурлан боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлэх;

- Ял эдэлж буй ялтан болон суллагагсдыг нийгэмшүүлэхэд чиглэгдсэн хууль эрх зүйн зохицуулалтыг “хяналт”-аас “дэмжлэг” үзүүлэх хэлбэрт шилжүүлж, эрх зүйн шинэчлэл, өөрчлөлтөд тулгуурлан ялтныг нийгэмшүүлэх шинэ тогтолцоог бий болгох, энэ чиглэлд хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлэх зэрэг болно.

Хууль сахиулах байгууллагуудын үндсэн чиг үүрэг нь эрх зүйн харилцаанд оролцогсдод хууль сахин биелүүлэх, хуулийн болон нийгмийн хэмжээ, ёс зүйн төлөвшлийг бий болгоход чиглэх бөгөөд гэмт хэрэг үйлдсэн ялтныг нийгэмшүүлэх ажил дахь хамтын ажиллагаа нь гэмт хэргийг бууруулах, урьдчилан сэргийлэх замаар олон нийтийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдэх юм.